



40

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 11

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

Нэг. Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэгийн орчмын бүртгэлгүй 2,795,164 /Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв / төгрөгний цэвэр усны шугамыг “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гуравдугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Мөнхтуяа, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах,
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА C. С. С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020-оны 01 дүгээр сарын  
24 ны өдрийн 14. тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэг  
данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Тоо хэмж ээ	Нийт дүн	Хурилтлагд сан элэгдэл	Үлдэх өртөг
1	Цэвэр усны шугам ф50	2019-01-01	м	2,795,164.96	0	2,795,164.96
<b>Нийт дүн</b>				<b>2,795,164.96 / Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв ерөн зургаан мөнгө/</b>		<b>2,795,164.96 / Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв ерөн зургаан мөнгө/</b>